



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

“БАЙКАЛТУР-2018” олон улсын аялал
жуулчлалын үзэсгэлэнд оролцох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 18.2.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/234 дүгээр захирамж, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оросын Холбооны Улсын Эрхүү хотод 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулагдах “БАЙКАЛТУР-2018” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход шаардагдах төсвийг хавсралт ёсоор баталсугай.

2. Гадаад томилолтод шаардагдах хөрөнгийг Нийслэлийн 2018 оны төсөвт тусгасан “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээ”-ний зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500067

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 03 сарын 26 өдрийн А/23 дугаар тушаалын хавсралт

1117339265
УОА0453 5284325

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЭРХҮҮ ХОТОД
ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Хугацаа: 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны хооронд

Д/д	Зардлын зүйл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тооцоо хийх хэлбэр
1	УБ-Эрхүү-УБ унааны зардал	-	-	2 000 000 төгрөг	Нэхэмжлэх
2	Зочид буудал	3 хүн*7 хоног 5 хүн*7 хоног	150 ам доллар 50 ам доллар	3 150 ам доллар 1 750 ам доллар	Бэлнээр
3	Зам хоног	3 хүн*7 хоног 5 хүн*7 хоног	60 ам доллар	3 360 ам доллар	Бэлнээр
4	Үзэсгэлэнгийн талбайн түрээс	40м ²	5 750 рубль	230 000 рубль	Нэхэмжлэх
5	Сэтгүүл материалын хэвлэлтийн зардал 80 нүүр /орос хэл дээр/	1000 ширхэг	4 000 төгрөг	4 000 000 төгрөг	Нэхэмжлэх
6	Сэтгүүлийн эх бэлтгэл, орчуулга	80 нүүр	-	400 000 төгрөг	Нэхэмжлэх
Нийт: 6 400 000 /зургаан сая дөрвөн зуун мянга/ төгрөг, 8 260 /найман мянга хоёр зуун жар /ам доллар, 230 000 /хоёр зуун гучин мянга/ рубль Гадаад валютыг тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцно.					

--ooOoo--